



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 69

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.2.4, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18,500,000 /арван найман сая таван зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 2,826,390 /хоёр сая найман зуун хорин зургаа мянга гурван зуун ер/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Дуа 51-59 улсын дугаартай Уаз-31514 маркыг автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3,000,000 /гурван сая/ тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Р.Мөнхбаясгаланд даалгасугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100157